

УУЛ УУРХАЙН ХӨГЖЛИЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨ БАГАТАЙ ТӨЛӨВЛӨХ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО



УУЛ УУРХАЙН ХӨГЖЛИЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨ БАГАТАЙ ТӨЛӨВЛӨХ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

УЛААНБААТАР
2018 ОН

ОРШИЛ


МАНАЙ УЛСАД УУЛ УУРХАЙН САЛБАР ЭРЧИМТЭЙ ХӨГЖИЖ БАЙГАА БА ЦААШИД Ч УЛАМ ХӨГЖИХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА. УУЛ УУРХАЙН САЛБАР НЬ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИНД ОЛОН ТАЛЫН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ НӨЛӨӨТЭЙ БАЙДАГ. ИЙМД ИРГЭД УУЛ УУРХАЙГ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД АЛЬ БОЛОХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ БАГАТАЙ ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ, УГ АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААР ЗОХИХ МЭДЛЭГТЭЙ БАЙХ НЬ ЗҮЙТЭЙ. ИНГЭСНЭЭР ТА АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭСВЭЛ ОЛГОХЫГ ХОРИГЛОХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГДСОН ТОХИОЛДОЛД ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ ХЭРХЭН БУУРУУЛАХ ТАЛААРХ ШИЙДВЭР ГАРГАХ, ТӨЛӨВЛӨХ ҮЙЛ ЯВЦАД ОРОЛЦОЖ, ЭРХ АШГАА ХАМГААЛАХ БОЛОМЖТОЙ БОЛНО. ТАНД ТОЛИЛУУЛАН БУЙ ЭНЭ ТОВХИМОЛД УУЛ УУРХАЙН ХӨГЖЛИЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨ БАГАТАЙ ТӨЛӨВЛӨХ, ЭНЭ САЛБАРЫН ЭЕРЭГ БА СӨРӨГ ТАЛУУД, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГДСОН ТОХИОЛДОЛД ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ ХЭРХЭН БУУРУУЛАХ, ТӨЛӨВЛӨХ, ШИЙДВЭР ГАРГАХАД НУТГИЙН ИРГЭД ОРОЛЦОХ БОЛОМЖ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЯЛБАРШУУЛАН ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.

УУЛ УУРХАЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨ БАГАТАЙ ТӨЛӨВЛӨХ НЬ



УУЛ УУРХАЙН САЛБАР НЬ МАНАЙ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ЧУХАЛ ХУВЬ НЭМЭР ОРУУЛДАГ. МАНАЙ УЛСАД УУЛ УУРХАЙН САЛБАР НЬ 2016 ОНЫ БАЙДЛААР ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 17.2%-Г БҮРДҮҮЛЖ БАЙНА (АМГТГ). ЦААШИД УУЛ УУРХАЙН САЛБАР ЭРЧИМТЭЙ ХӨГЖИХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА. ИЙМД УУЛ УУРХАЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨ БАГАТАЙ ТӨЛӨВЛӨХ, ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛ НЭН ЧУХАЛ.

УУЛ УУРХАЙН ЭЕРЭГ БА СӨРӨГ ҮР ДАГАВАР



УУЛ УУРХАЙН ТӨСЛӨӨС БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ



ХОГ ХАЯГДАЛ



АГААРЫН БОХИРДОЛ



ХӨРСНИЙ БОХИРДОЛ



УСНЫ БОХИРДОЛ



ТООСЖИЛТ



АМЬТАН ҮРГЭЖ ДАЙЖИХ



ҮРГАМЛАН НӨМРӨГ
ТАЛХЛАГДАХ, УСТАХ



БАЙГАЛЬ ОРЧИН



ХҮНИЙ ЭРҮҮЛ
МЭНД




НИЙГМИЙН ЗӨРЧИЛ



МАРГААН

АШИГЛАЛТ, ХАЙГУУЛЫН ТУСГАЙ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, БАЙГАА ИРГЭД ХЯНАЛТ ТАВИХ



ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ТӨСЛИЙН АЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНД Х, ОРОЛЦОХ БОЛОМЖ

ШИГЧ НЬ БАЙГАЛЬ
БУСАД АСУУДЛААР
- Явуулж, нутгийн
й гэрээ байгуулж
ла.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль
орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ
биелүүлэх баталгаа болгон байгаль орчныг
хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн
жилийн зардлын 50 хувьтай тэнцэх
хэмжээний мөнгөн хөрөнгийг тусгай дансанд
шилжүүлнэ.

НӨЛӨӨЛЛИЙН
ХИЖ БАЙГАА
ХЭРЭГЖИХ НҮТАГ
АА, ТӨСЛИЙН
ИН ИРГЭД, ОРШИН
ОР САНАЛ АВЧ,
Н БАЙГУУЛНА.

УУРХАЙН ХААЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТУХАЙН ОРОН
НУТГИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ, БАЙГАЛЬ ОРЧНЫ
ХЯНALTЫН УЛСЫН БАЙЦААГЧ, БУХ ШАТНЫ ЗАСАГ
ДАРГА, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГА
БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
ХЯНАЛТ ТАВИНА.

БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ,
ГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
АР ГҮЙЦЭТГҮҮЛНЭ.

Тусгай зөвшөөрөл дуусгавар болсноор тусгай
зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг
хамгаалах, нөхөн сэргээх, уурхайг хаах
талаарх холбогдох хувь тогтоомжийн дагуу
хүлээх үүргээ чөлөөлөгдхгүй.

ГЛАЛТЫН ТУСГАЙ
ЙГ АМГТГ-Т ГАРГАНА.
ЫН ЯВЦАД БАЙГАЛЬ
ӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ
СЕЛҮҮЛЖ АЖИЛЛАСАН
АВСАРГАНА.

Хайгуулын тусгай зөвшөөрөл нь хүчин
төгөлдөр байх хугацаа дууссан, өөрийн
хүсэлтээр бухээд нь эсвэл хэсэгчэн буцаах,
төрийн захиргааны байгууллага тусгай
зөвшөөрлийг цуцалсан болон хуульд заасан
бусад үндэслэлээр дуусгавар болно.

ШИГЧ НЬ БАЙГАЛЬ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ОРЧНЫХ ХЯНALTЫН
ЗАСАГ ДАРГАД
ЭР.

ОРӨЛ ЭЗЭМШИГЧ НЬ
ХОЙШ ЗОХОНОГИЙН
ААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
ГАРАР БАТЛУУЛНА.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний
байгаль орчныг нөхөн сэргээх үйл
ажиллагданд олон нийтийн хяналт тавих үүрэг
бухий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон
ажиллуулж болно.

УУЛ УУРХАЙН ТӨСЛӨӨС БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН



УУЛ УУРХАЙН ТӨСЛӨӨС БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АСУУДЛЫГ АШИГТ МАЛТАЛЫН ТУХАЙ, БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИУД, ТЭДГЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЖУРАМ, АРГАЧЛАЛААР ТУСГАЙЛАН ЗОХИЦУУЛДАГ ҮҮНД:

- БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ
- БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ: 2013 ОНЫ 11 ДУГЭЭР САРЫН 16. ДУГААР 374
- БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2014 ОН 04 ДУГЭЭР САРЫН 10- НЫ ӨДРИЙН А-117 ДУГААР ТУШААЛ.
- БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ: БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2014 ОНЫ 04 ДУГЭЭР САРЫН 06-НЫ ӨДРИЙН А-05 ТУШААЛ.
- БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОOG ХАНГАХ ТУХАЙ ЖУРАМ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2014 ОНЫ 01 ДУГЭЭР САРЫН 06- НЬ ӨДРИЙН А-03 ТООТ ТУШААЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

НЭГЭНТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГДСОН ТӨСЛҮҮДИЙН ХУВЬД БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АСУУДЛЫГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛДАГ. ИРГЭД УГ ХУУЛЬД ЗААСАН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ, БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААР ЗОХИХ МЭДЛЭГТЭЙ БАЙХ НЬ ЗҮЙТЭЙ.

- БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ГЭЖ ИРГЭН, АЖ АХҮЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГААС ТОДОРХОЙ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД БАЙГАЛЬ ОРЧИНД УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮР ДАГАВРЫГ УРЬДЧИЛАН ТОДОРХОЙЛЖ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ЗЭРЭГ АРГА ХЭМЖЭЭГ ТОГТООХЫГ ХЭЛНЭ.
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХЫН ӨМНӨ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГААР ХИЙЛГЭХ ҮҮРЭГТЭЙ.
- ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АЖ АХҮЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЛМААС ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД, БАЙГАЛЬ ОРЧИНД ХОХИРОЛ УЧРУУЛЖ БАЙГАА БОЛОН УЧРУУЛСАН БОЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ҮНЭН ЗӨВ ХИЙГДСЭН ЭСЭХЭД ХЯНАН МАГАДЛАГАА ХИЙНЭ.

(БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУЛИАС)



БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОХ БОЛОМЖ

- ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭД ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ ЯВЦДАА ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗАХИРГАА, ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ НУТГИЙН ИРГЭД, ОРШИН СУУГЧДААС АЛБАН ёСООР САНАЛ АВЧ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛНА.
- БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОOG ХАНГАХ ЖУРМЫН ДАГУУ УГ ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТ ОРОЛЦОХ, САНАЛАА ХЭЛЭХ БОЛОМЖТОЙ. ҮҮНД:
 - ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЭРХ БУХИЙ АЖ АХУЙН НЭГЖ НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЕ ШАТНЫ ЯВЦДАА ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОOG ХАНГАНА.
 - НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЕ ШАТАНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОOG ЗӨВЛӨЛДӨӨН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, САНАЛ АСУУЛГА ЯВУУЛАХ ЗАМААР ТӨСЛИЙН ШУУД БОЛОН ШУУД БУС НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЖ, ИРГЭДИЙН АМЬЖИРГАА, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ТУСГАХАД АНХААРАХ.
 - ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТӨСЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ЭЭРЭГ, СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨЖ БОЛЗОШГҮЙ ИРГЭДЭД ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛЖ, ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОOG ХАНГАХАД ШААРДАГДАА БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЖ ӨГЧ БОЛНО.
 - ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ БУХИЙ АЖ АХУЙН НЭГЖ НЬ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧТЭЙ ХАМТРАН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛЖ ДУУССАНЫ ДАРАА ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, ОЛОН НИЙТИЙН САНАЛЫН НЭГДСЭН ДҮНГ АЖЛЫН 15 ӨДРИЙН ХУГАЦААНД ТУХАЙН НУТАГ ДЭВСГЭРИН БАГ, ХОРООНЫ НИЙТИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЖ САНАЛ АВНА.

(Ашигт малтмалын тухай хууль, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн)
оролцоог хангах тухай журмаас



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



ИРГЭД МӨН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААР ТОДОРХОЙ ОЙЛГОЛТТОЙ БАЙХ НЬ ЗҮЙТЭЙ.

- Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, дүйцүүлэн хамгаалах зэрэг асуудлыг тусгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэгтэй.
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.
- Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.
- Иргэн та төсөл хэрэгжүүлэгч хуулиа хүлээсэн үүргээ хангалтгуй биелүүлж байна гэж үзвэл санал, хүсэлтээ аймаг, сумын засаг дарга, улмаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан гаргаж болно.

(БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ)
ХУУЛИАС

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАТАЛГАА



- Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тусгай дансанд төвлөрүүлнэ.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлэгүй бол сум, дүүргийн засаг дарга уг барьцаа хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.

(БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТУХАЙ БОЛОН АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИАС)

УУЛ УУРХАЙГААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ШАТЛАЛ

Уул уурхайн болон хөгжлийн бусад төслийдийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөж хэрэгжүүлэхийн тулд олон улсад нөлөөллийг бууруулах шатлал буюу нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнүүдийг цогцоор хэрэгжүүлдэг байна. Нөлөөллийг бууруулах шатлалыг манай улсын хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн хэрэгжүүлж болох тайлбарыг энд товчлон хүргэж байна.

НӨЛӨӨЛЛӨӨС ЗАЙЛСХИЙХ



НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ



ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ



НӨХӨН СЭРГЭЭХ



УУЛ УУРХАЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨ БАГАТАЙ
ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ БҮРЭЛДЭНЭ

НӨЛӨӨЛЛӨӨС ЗАЙЛСХИЙХ

ЭКОЛОГИЙН ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ
ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ГАЗАР НУТАГ



500

КМ

ҮЕ ШАТ	ОН	ГАЗРЫН ТОО	ТАЛБАЙН ХЭМЖЭЭ (КМ2)	УЛСЫН ГАЗАР НУТАГТ ЭЗЛЭХ %
I ШАТ	2016 ОН	31	110,044.12	7.0%
	2017-2020 ОН	59	137,480.16	8.8%
II ШАТ	2021-2025 ОН	47	95,190.45	6.1%
III ШАТ	2026-2030 ОН	78	89,523.56	5.7%
НИЙТ		215	432,238.29	27.6%


СУДАЛГААНЫ БУС

- УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР
■ ЭКОЛОГИЙН ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ
ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ГАЗАР НУТАГ


I - ХЭЭРИЙН БУС	108	206.2	КМ2
II - ГОВИЙН БУС	150	869.8	КМ2
III - МОНГОЛ АЛТАЙ, АЛТАЙН-АР ГОВЬ	80	274.7	КМ2
IV - ХАНГАЙ, ХӨВСГӨЛ	94	803.2	КМ2

- ЮУНЫ ӨМНӨ ЭКОЛОГИЙН ХУВЬД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ГАЗРУУДАД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ НЬ ЗҮЙТЭЙ.
- ЭКОЛОГИЙН ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ГАЗРУУДАД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХГҮЙ БАЙХ НЬ БАЙГАЛЬ ХАМГААЛЛААС ГАДНА МАЛЫН БЭЛЧЭЭР, УСЫГ ХАМГААЛАХАД АЧ ХОЛБОГДОЛТОЙ.
- ЭКОЛОГИЙН ХУВЬД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ГАЗРУУДАД АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС СЭРГИЙЛЭХИЙН ТУЛД ТЭДГЭЭР ГАЗРЫГ УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВЧ БОЛНО.

ГАЗАР НУТГИЙГ ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТАД АВАХ ҮЕ ШАТУУД



НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ



- Төсөл хэрэгжүүлэгч нь өмнө өгүүлсэн уул уурхайн төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үүрэгтэй.
- Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаварыг тогтоох
- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй бохирдлыг бууруулахад боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй техник, технологийг ашиглах үүрэгтэй.

НӨХӨН СЭРГЭЭХ



- АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОС, ЦАЦРАГ ИДЭВХТ БОДИС АШИГЛАХ ТӨСЛҮҮД НЬ НӨХӨН СЭРГЭЭЛТ БОЛОН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ БОЛОВСРУУЛАХ, ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГТЭЙ.
- ТЕСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НЬ УУРХАЙН ХААЛТЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫГ БҮРЭН ДУУСГАСАНЫ ДАРАА БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТИН ДҮГНЭЛТ БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АЛБАНЫ ДҮГНЭЛТ ГАРГУУЛЖ, ТУХАЙН ОРОН НУТГИЙН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД ЗОХИХ ЖУРМЫН ДАГУУ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ҮҮРЭГТЭЙ.

(БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИАС)
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН БОЛОН ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ИРГЭД ДУНДАСАА СОНГОН АЖИЛЛУУЛЖ БОЛНО.

(АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИАС)

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ



- АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОС, ЦАЦРАГ ИДЭВХТ БОДИС АШИГЛАХ БҮХ ТӨСЛҮҮД ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН ХАМТ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГТЭЙ.
- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ТӨЛӨВЛӨХ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАН ХЭРЭГЖҮҮЛНЭ.

(БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИАС)

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГЭЖ ЮУ ВЭ?

ТӨСӨЛ ХЭРЭГЖИХЭЭС ӨМНӨ



ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ЯВЦАД




ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ




ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГЭЖ ТӨСЛИЙН НӨЛӨӨНД ӨРТӨГДӨН УНАГАН ТӨРХ, ХЭВ ШИНЖ, АМЬДРАХ ОРЧНОО АЛДСАН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ БУЮУ АМЬТАН УРГАМЛЫГ ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨНТЭЙ АДИЛ ТӨСТЭЙ ЭКОЛОГИЙН НӨХЦӨЛ БУХИЙ ГАЗАРТ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ ХЭЛНЭ.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫГ ХЭРХЭН ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?




- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ, ЖУРАМ, АРГАЧЛАЛЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛНЭ.
- МАНАЙ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ДҮРСТ ХАРУУЛСАН ҮЕ ШАТЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛНЭ.
- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НУТГИЙН ИРГЭД ОРОЛЦОХ БОЛОМЖТОЙ.

ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ ГАЗРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ




- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН ТУЛД ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ ГАЗРЫН ХЭМЖЭЭГ ӨМНӨ ДУРЬДСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ТОГТООНО.
- ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ ГАЗАРТ УУРХАЙН УХАШ, ОВООЛГО, ЗАМ, ТАЛБАЙ, АЖЛЫН БАЙР, АЖИЛЧДЫН СУУЦ ЗЭРЭГ ТУХАЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ГАЗАР АШИГЛАЛТЫН БУХИЙ Л ХЭЛБЭР ОРНО.
- ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ ГАЗРЫГ ИХ, ДУНД, БАГА ГЭСЭН НӨЛӨӨЛЛИЙН ЗЭРЭГТ ХУВААЖ ГА-ГААР ТОГТООНО.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ



- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ГАЗРЫГ ТОГТООХДОО ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ ГАЗРЫН ХЭМЖЭЭГ ҮНДЭСЛЭНЭ. ҮҮНИЙ ТУЛД ӨМНӨ ДУРЬДСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ ГАЗРЫН ХЭМЖЭЭГ (ГА-Р ТОГТООСОН) 5 ТУСГАЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ХАМААРАХ УТГААР ҮРЖИХ ЗАМААР ТОГТООДОГ.
- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭ НЬ ИХЭВЧЛЭН ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ ГАЗРААС ИХ ХЭМЖЭЭТЭЙ БАЙДАГ. ЗУРАГТ ХАРУУЛСАН ЖИШЭЭГ ХАРНА УУ.


ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГАЗРЫГ ТОГТООХ



ДЭЭРХ ЗУРАГТ УУЛ УУРХАЙН ТӨСӨЛ НЬ "А" ТӨРЛИЙН ЭКОЛОГИЙН НӨХЦӨЛ БУХИЙ ГАЗАРТ ХЭРЭГЖИХЭЭР БОЛСОН БОЛ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГАЗРЫГ МӨН "А" ТӨРЛИЙН ЭКОЛОГИЙН НӨХЦӨЛ БУХИЙ ГАЗАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР СОНГОНО, ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГАЗРЫГ СОНГОХДОО ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨНТЭЙ ИЖИЛ ТӨСТЭЙ АМЬТАН УРГАМАЛ БУХИЙ ГАЗАРТ СОНГОХ НЬ ЗҮЙТЭЙ.

- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГАЗРЫГ ТОГТООХДОО АЛЬ БОЛОХ НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨНТЭЙ ИЖИЛ ЭКОЛОГИЙН НӨХЦӨЛ БУХИЙ ГАЗАРТ СОНГОНО.
- МӨН ТУХАЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН ХИЛ ХЯЗГААРЫГ ХАРГАЛЗАН ҮЗНЭ.
- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГАЗРЫГ ТОГТООХДОО НУТГИЙН ИРГЭД САНАЛАА ӨГӨХ БОЛОМЖТОЙ.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ТООЦОХ



- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ НЬ ДАРААХ ЗАРДЛУУДААС БУРДЭНЭ:
 - ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ ЗАРДАЛ
 - ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГАЗАРТ ХИЙХ СУУРЬ СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗАРДАЛ
 - ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ МЕНЕЖМЕНТИЙН ЗАРДАЛ
 - ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГ ЖИЛИЙН ЗАРДАЛ (ГА ТУТАМД 5 ТӨЛБӨРИЙН НЭГЖ)

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИШЭЭ



- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨН УНАГАН ТӨРХ, ХЭВ ШИНЖЭЭ АЛДСАН ГАЗАР НУТАГ, АМЬТАН, УРГАМЛЫГ НӨХӨН ХАМГААЛАХ ЗОРИЛГОТОЙ.
- ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРИМ ЖИШЭЭГ ДООР ЖАГСААВ. ҮҮНД:
 - АМЬТАН, УРГАМАЛ, ОРЧНЫ ГАЗАР НУТГИЙГ ХАМГААЛАХ,
 - ХУУЛЬ БУС АШИГЛАЛТ, АГНАЛТЫГ БУУРУУЛАХ, ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭ,
 - ОРЧНЫ ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ БУУРУУЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ... ГЭХ МЭТ

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНД НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- Өмнө өгүүлсэнчлэн төслийн нөлөөллийг бууруулах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэхэд нутгийн иргэд оролцох боломжтой.
- Иргэн та, төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төслийн нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрхэн төлөвлөн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, санаалаа илэрхийлэн өөрийн амьдарч буй нутгийн байгаль орчин, эрүүл мэндээ хамгаалахад оролцон иргэний үүргээ биелүүлээрэй.



УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТАЛААР ИЛҮҮ МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ ДАРААХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛНО. МӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЖИЛТНУУД, БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН БАЙЦААГЧ, ГАЗРЫН ДААМАЛ НАРААС ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙГ АВЧ БОЛНО.

- АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ
- БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ
- БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ: 2013 ОНЫ 11 ДҮГЭР САРЫН 16. ДУГААР 374
- БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2014 ОНЫ 04 ДҮГЭР САРЫН 10-НЫ ӨДРИЙН А-117 ДУГААР ТУШААЛ.
- БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЖЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ: БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2014 ОНЫ 01 ДҮГЭР САРЫН 06-НЫ ӨДРИЙН А-05 ТУШААЛ.
- БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОOG ХАНГАХ ТУХАЙ ЖУРАМ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2014 ОНЫ 01 ДҮГЭР САРЫН 06-НЫ ӨДРИЙН А-03 ТООТ ТУШААЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАРИМ СТАНДАРТЫН ЖАГСААЛТ

- АГААРТ БАЙХ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХҮЛЦЭХ ХЭМЖЭЭ. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА, MNS5885-2008
- АГААРЫН ЧАНАР. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА, MNS4585- 2007
- АГААРЫН ЧАНАРЫН НИЙТЛЭГ АСУУДАЛ. НАРИЙН ШИРХЭГТЭЙ ТООСЫГ ТОДОРХОЙЛОХ АРГА MNS5364-2004
- АХҮЙН ХЭРЭГЦЭЭ, УНДНЫ ЗОРИУЛАЛТАЙ УС. ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА, MNS 3936-86
- УНДНЫ УС. ЭРҮҮЛ АХҮЙН ШААРДЛАГА, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ, MNS 0900-2005
- БОХ. УСАН МАНДАЛ. УС АШИГЛАЛТЫН АНГИЛАЛ, MNS 0017-1-1-14-80
- УСАН МАНДАЛ. ГАЗРЫН ДООРХИ УСЫГ БОХИРДЛООС ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА MNS 334282
- УСАН МАНДАЛ ГАДАРГЫН УСНЫ ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ, MNS 4047:98
- УСАН ОРЧНЫ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ, ЕРӨНХИЙ ШААРДЛАГА, MNS 4586-98
- УСНЫ ЧАНАР. ГАЗРЫН ДООРХИ УСЫГ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS6148-2010
- УНД АХҮЙН ХЭРЭГЦЭЭНИЙ БОЛОН ҮЙЛДВЭРИЙН УС ХАНГАМЖИЙН ЗОРИУЛАЛТАЙ УС. ХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА, ДЭЭЖ АВАХ, ХАДГАЛАХ ТЭЭВЭРЛЭХ, MNS3934-1986
- УСНЫ ЧАНАР, MNS 1306107-1:2002
- ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД НИЙЛҮҮЛЭХ ЦЭВЭРШҮҮЛСЭН БОХИР УС. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА MNS 4943-2011
- ГҮНИЙ УСНААС ДЭЭЖ АВАХ ЗӨВЛӨМЖ, MNS5667-11-2000
- БОХ. ГАЗАР. ГАЗАР ЭДЭЛБЭР. ГАЗАР АШИГЛАЛТ, MNS3473-83
- ЭВДЭРСЭН ГАЗАРТ ХҮЧИЛТ ХИЙХ ХӨРС, MNS4917-2008
- УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, MNS5917-2008
- ЭВДЭРСЭН ГАЗРЫГ УРГАМАЛЖУУЛАХ. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА, MNS5918-2008
- ХӨРСНӨӨС ШИНЖИЛГЭЭНД ДЭЭЖ АВАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА, MNS3298-91
- ХӨРСНИЙ ЧАНАР. ХӨРС БОХИРДУУЛАГЧ БОДИС, ЭЛЕМЕНТҮҮДИЙН ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ, MNS 5850-2008
- БОХ. ХӨРС. АРИУН ЦЭВРИЙН БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН НЭР ТӨРӨЛ, MNS 3985-1987



"ЦЭВЭР ХӨГЖЛИЙН ТӨВ" ТББ ЭМХТГЭВ